**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ 2022 ОНЫ ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022.11.10

| Д/д | Үзүүлэлт | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ | ХШҮ-ний үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд “Аймгийн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл”-ийн 4 заалт, “Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 заалт, үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний 2 заалт , аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2 заалтыг бүрэн хэрэгжүүлж, тайланг хагас, бүтэн жилээр хугацаанд нь гаргах. | “Аймгийн хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан 6 арга хэмжээ, Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 10 арга хэмжээ, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 9 заалтыг тус тус бүрэн хэрэгжүүлэн биелэлтийн тайланг СУГ-т хугацаанд нь хүргүүлсэн. | 100% | |
| 2 | Соёлын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан **2.1, 2.2, 2.3, 2.4, 2.8** заалтыг 100 хувь бүрэн хэрэгжүүлж, тайланг хагас, бүтэн жилээр хугацаанд нь гаргах. | **2.1. Соёлын тухай хуулийн 21.1.11**, **Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга төлөвлөгөөний 2.6.2.2**<br>Иргэдийн хамтдаа амьдрах соёл ахуйн соёл, монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлээр контент, гарын авлага хийж хүүхэд залуучуудад ойлгуулан таниулан сурталчлах:<br><br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149-р зарлигт Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлийг томьёолж монголын түүх сурвалжуудыг ишлэсэн “ЭРДЭНИЙН СУДАР”-ыг төрийн ордноо дээдлэн залах зарлиг буулгасантай холбогдуулан “**МОНГОЛ ХҮНИЙ ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭХ 9-Н ҮНЭТ ЗҮЙЛС**”-ээр 85 гарын авлага бэлтгэж ЕБ-ын 2 дугаар сургууль, 5 дугаар лаборатори сургуулийн дунд ахлах ангийн нийт 300 сурагчдад суртчилан таниулж, контент бэлгэсэн.<br>Боржигины өв соёлыг сурталчилан “Боржигины өв соёл” номын танилцуулга контент бэлтгэсэн. Контентуудыг “Говьсүмбэр аймгийн | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Нийтийн Номын Сан” пэйж хуудсанд байршуулж сурталчилан таниулах арга хэмжээг зохион байгуулсан.<br><br>**3 арга хэмжээнд нийт 1303-н уншигч, иргэд үзэж мэдээлэл авсан байна.**<br><br>**2.2.** Номын сангийн тухай хуулийн 23.2 Номын санд шинэ номын баяжилт хийхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх<br>МУ-н Соёлын сайдын 2022.03.25-ны дөрийн А/60 дугаар тушаалын дагуу Соёлын яамнаас орон нутгийн соёлын байгууллагуудын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардалд шинэ ном худалдан авхад 7000.000 сая, Хүүхдийн номын фондыг баяжуулхад 4.750.000 Нийт 11.750.000 төгрөгийг шийдвэрлэж өгсөн. Фондын сан хөмрөгийг 236 нэр төрлийн 691 ширхэг 11.750,000 төгрөгийн номоор баяжуулсан.<br><br>2.3. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.17, Номын сангийн тухай хуулийн 24.4 БСШУСайдын 2018 оны А/683 тушаал, МУ-ын ерөнхийлөгчийн 158-р зарлиг орон нутагт Номын баяр-2022 арга хэмжээ зохион байгуулах.<br><br>2022 оны 05 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022”<br>“Илүү их уншъя”, “Номын баяр”-ын хаврын үйл ажиллагааны хүрээнд: 12 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 4.496.416 мянган төгрөг зарцуулсан. 2541 иргэд, уншигчид хамрагдсан.<br><br>2022 оны 09 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022” “Номын баяр”-ын намрын үйл ажиллагааны хүрээнд 16 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 6.003.584 мянган төгрөг зацуулсан. 2836 уншигч, иргэд оролцсон. Хавар, Намрын 2 үйл ажиллагааны хүрээнд: 28 арга хэмжээ зохион байгуулсан. Нийт 5377 иргэд уншигчид хамрагдсан**.**<br><br>**2.4. Номын сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2** Сан хөмрөгт байгаа урагдаж гэмтсэн ном хэвлэлийг сэргээн засварлах | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Уншлагаар урагдаж гэмтсэн 132 ширхэг номыг сэлбэн засаж уншлагад гаргасан.<br><br>**2.8. Монгол хэлний тухай хуулийн 7.2, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” 3.2.15** “Хос бичигтэн байгууллага” болох арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх<br><br>Л.Лоохууз багшаар монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтуудыг 3 удаа танхимаар авсан.<br>Говьсүмбэр номын сан монгол бичгийн хичээлийн групп чат нээж өдөр бүр Л.Лоохууз багшаар хичээл заалгаж байна.<br><br>Албан хаагчид монгол бичгээ сурахад Э.Олонцэцэг багшийн гаргасан Үндэсний бичгээ шамдан сурцгаая-1 номыг бие даан ашиглаж байна.<br><br>Монгол бичгийн ахисан шатанд А.Чимэгмаа, Б.Аасүрэн, нар чимээ апп-ыг ашиглаж бичиж байна.<br>Монгол бичгийн самбарт “Уран бичлэг”, “Зүйр онч үгс”, Ойролцоо утгатай үг”, Шинэ мэдээ, мэдээлэл”, “Монгол бичгийн дүрэм” гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр бичиж байршуулсан.<br><br>Албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн.<br>Албан хаагчдын өрөөний хаягийг болон энгэрийн тэмдэгийг монгол бичгээр бичсэн. | | |
| 3 | Иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | Байгууллагын цахим хуудсанд өдөр тутмын мэдээ мэдээлэл, Монгол бичгээр зүйр цэцэн үг, уриалсан, сургамжит мэдээлэл, номтой өглөөний мэнд зэрэг соён гэгээрүүлэх танин мэдэхүйн 1090 мэдээллийг хос бичгээр бичиж Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан пэйж хуудсанд байршуулсан. Нийт 10500 уншигч, иргэд хамрагдсан байна<br><br>Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын сангийн пэйж хуудсанд давхардсан тоогоор 548 цахим номыг байршуулахад 14067 уншигч хандалт хийж уншсан байна. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Төр, төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг сайжруулах, өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Татварын хэлтэс, АЗДТГ, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Нийтлэг үйлчилгээний алба, Статистикийн хэлтэс, Байгаль орчин аялал жуучлалын газар, Сум дундын ойн анги, Төрийн банк, Аймгийн хороо, Хас банк, Хаан банк, Соёл урлагийн газар, Энхбилэг эмнэлэг, Тээвэр зохицуулалтын алба, Петротрак ХХК, Боржигин чуулга, Биеийн тамир спортын хороо, Балдан засаг, Чойр солилцох тасаг, Ахмадын хороо, Онцгой байдлын газар, 6-р цэцэрлэг Өмгөөлөгчдийн холбооны салбар зөвлөл болон 5-р сургууль, Цагдаагийн хэлтэс, Боржигин өв музей, Боржигин чуулга зэрэг 39 төрийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан зөөврийн номын үйлчилгээ үзүүлсэн.<br><br>**Төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор:**<br>➢ "Боржигидай сэцэн" салбар,<br>➢ "Жанжин Чойрын Данжин Сахиус",<br>➢ "Хос эгшиглэн" бүжгийн холбоо<br>➢ "МОНАД",<br>➢ "ХБИ-ийн Өөдрөг золбоо ТББ<br>➢ "Эрэгтэйчүүдийн холбоо",<br>➢ "Боржигин гоёл" ХХК,<br>➢ "Талын шонхорууд" гүйлтийн клуб,<br>➢ Монголын "АА" нийгэмлэгийн "Андын хүч" салбар<br>Аймгийн "Пара олимпын холбоо" зэрэг 10 байгуулагатай хамтран хэрэгжүүлэх ажлын санал солилцон төлөвлөж 2021 онд байгуулсан гэрээгээ сунгаж баталгаажуулан ажиллаж байна. | 100% | |
| 5 | Иргэдийг мэдээллээр хангах, мэдээ, мэдээллийг хурдан шуурхай хүргэх, аливаа уулзалт, зөвлөгөөн, хурал цуглаанд иргэдийн санал бодлыг сонсож, шийдвэрлэж ажиллах. Аймгийн www.govisumber.gov.mn цахим хуудсанд 7 хоног бүр үйл ажиллагааны мэдээ мэдээллийг байршуулах. | **Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сангийн цахим пэйж хуудсаар:**<br><br>➢ Өглөөний мэндчилгээ, үйл ажиллагаатай холбоотой шинэ мэдээллийг 1580 удаа,<br>➢ Аймаг орон нутгийн холбогдолтой цаг үеийн мэдээ, мэдээллийг 1230 удаа тус тус иргэдэд хүргэж ажилласан.<br>Байгууллагад иргэдээс ирсэн санал, гомдол, хүсэлт байхгүй болно.<br><br>Монгол бичгээр зүйр цэцэн үг, уриалсан, сургамжит мэдээлэл, | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | номтой өглөөний мэнд зэрэг Нийт 1090 мэдээлэл хос бичгээр бичиж байршуулан үйл ажиллагааны мэдээллийг иргэд уншигчдад сурталчилсан.<br><br>Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022 арга хэмжээ УИХ-н дарга Г.Занданшатарын ивээл дор "ИЛҮҮ ИХ УНШЪЯ" уриан дор "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2022 баярын үйл ажиллагааны мэдээлэл, Lib4 номын сангийн цогц программ хангамжийн шинэчлэлийг хийлгэж Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн номын электрон каталогийг GOVISUMBER.LIB4U.NET линкээр болон QR кодыг уншуулан иргэд уншигчдыг гар утаснаасаа харах боломжийг бүрдүүлсэн зэрэг мэдээллүүдийг тус тус . Аймгийн www.govisumber.gov.mn цахим хуудсанд байршуулахаар хүргүүлсэн. | | |
| 6 | Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний соёл, угтах, үдэх үйлчилгээний чанарт анхаарах. Төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлага, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, Удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх. | **Төрийн байгууллагын соёлын үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүртээмжтэй хүргэх, соёлтой үйлчлэх, угтах үдэх үйлчилгээний хүрээнд:**<br>Байгууллагын харуулын өрөө болон үүдний хэсгийг засварлан угтах, үдэх үйлчилгээг хийж, үйлчилгээний соёл албан хаагчдын ёс хариуцлага хандлагыг дээшлүүлэн ажиллаж байна.<br><br>Байгууллагын албан хаагчдын ёс зүй, хариуцлага, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, үүднээс төрийн албан хаагчийн ёс зүйн булан байгуулж, төрийн албан хагчийн ёс зүйн тухай хууль, дүрмийг албан хаагчдад танилцуулан мөрдүүлэн ажиллаж байна.<br><br>**Удирдлагын манлайлалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**<br>Номын сангийн үйлчилгээний Программын шинэчлэлийг хийлгэх 570,000 төгрөгийг Соёлын яамны соёл гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэгт хүсэлт гарган шийдвэрлүүлж 2022.04.22-ны өдөр "Волвес ХХК"-тай гэрээ байгуулан Lib4 номын сангийн цогц программ хангамжийн шинэчлэлийг хийлгэж Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн номын электрон каталогийг GOVISUMBER.LIB4U.NET линкээр болон QR кодыг уншуулан иргэд, уншигчдыг гар утаснаасаа харах боломжийг бий болгосон. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ДЗОУБ Бор-Өндөр 1 ОНХ-т хүсэлт гарган байгууллагын албан хаагчийн хэрэгцээнд өнгөт принтер, скайнер, цаас нуруулдагч, бичгийн тавиур, бичгийн хавтас, толь, өлгүүр зэргийг авч албан хаагчид хуваарилан өгч ажиллах нөхцөл боломжийг сайжруулсан.<br><br>**Соёл урлаг танин мэдэхүйн 20 контент нэвтрүүлгүүдийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэд уншигчдыг мэдээ мэдээллээр хангаж үйлчилгээний төрөл хүртээмжийг нэмэгдүүлсэн. Үүнд:**<br>➢ Үндсэн хуулийн өдөрт” зориулан “ЭРХЭЭ ХАМГААЛАХ ЭЦЭГ ХУУЛИА ДЭЭДЭЛЬЕ”<br>➢ Шинэ номын танилцуулга<br>➢ Сар шинийн баярын өдөрт” зориулан Боржигоны өв соёл номын танилцуулга<br>➢ МУ-ын Төрийн шагналт үргэлжилсэн үгийн зохиолч Ренчины “Чойномын мэндэлсэн өдөрт зориулан товч намтар болон Номын үзэсгэлэнгийн танилцуулга<br>➢ Соёлын яам, Чингис хааны өв,соёлын хүрээлэнгээс зохион байгуулж буй “Чингис хаан - 860“ хүүхдийн яруу найргийн наадмын удирдамжийн хүрээнд 20 “Монголын нууц товчоо” номын цуврал танилцуулга<br>➢ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Байгаль дэлхийгээ хамгаалцгаая цуврал 1,2,3<br>➢ Эх орончдын өдөрт зориулсан номын үзэсгэлэн<br>➢ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж номтой уулзалт мэндчилгээ<br>➢ Ковидын эсрэг хамтдаа шторк<br>➢ Иргэдийн хамтдаа амьдрах соёл ахуйн соёл, монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйл<br>➢ Нээлттэй хаалганы өдөрт<br>➢ Гавьяат зоо техникч Ц.Тэрбишийн “КАРАКУЛЬ ХОНЬ” номыг уншигч иргэдэд сурталчлах<br>➢ Ж.Дансранжав 90 жил контент №1,2,3<br>➢ “Номын баяр говьсүмбэр”<br>➢ Говьсүмбэр аймгийн тухай<br>➢ Монгол сакура<br>➢ Чойрын богд | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ➢ Боржигин нутаг<br>➢ Боржигин морин хуур<br>➢ Боржигин байшин Нийт 4006 уншигч, иргэд үзэж хамрагдсан.<br>**Хил хязгааргүй номын сан" төслийн хүрээнд:** Аймгийн Нийтийн Номын сангийн болон Сумдын болон ЕБС-иудын номын санч мэргэжилтэнгүүдийг чадавхижуулах сургалт, хэлэлцүүлэгийг Австралийн Элчин Сайдын Яам, Монголын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбоотой хамтран зохион байгуулсан. Нийт 19 номын санч харагдсан.<br><br>**Номын фондын сан хөмрөгийг Төсөв, Хөрөнгө оруулалт, Бэлэг хандиваар Нийт 604 нэр төрлийн 1361 ширхэг 23.462.024 төгрөгийн номоор баяжуулсан.** | | |
| 7 | Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах, хамтран ажиллах | ЕБ-ийн 1,2,3,4,5-р сургуулиудын номын сан, Сумдын соёлын төвийн номын сан, ЕБ-ийн 1,2,3,4,5-р сургуулийн МХУЗ багш, Дуу хөгжмийн багш, сурагчид, 1,2,5,6 цэцэрлэгүүд, БСУГ, Статистикийн хэлтэс, Боржигин өв музей, Боржигин чуулга, Нэгдсэн эмнэлэг, Шуудан холбооны газар, Биеийн тамир спортын газар, зэрэг төрийн байгуулагуудтай Зөөврийн номын үйлчилгээ, Цахим ном уншлагын аян болон Соёл олон нийтийн ажлуудыг зохион байгуулж хамтран ажилласан.<br><br>**Нийт 34 төрийн байгуулагуудтай хамтран ажилласан** | 100% | |
| 8 | Удирдах ажилтын шуурхай зөвлөгөөнөөд өөрийн биеэр оролцож, шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар болон аймгийн Засаг даргаас хууль тогтоомжийн хүрээнд өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь биелүүлж, үр дүнг тайлагнах | Аймгийн Удирдах Ажилтны Шуурхай Зөвлөгөөнд өөрийн биеэр хоцрогдолгүй, тасалдалгүй бүрэн 100% хамрагдсан.<br>02 дугаар сарын 28-ны өдөр АУАШЗ-нд байгууллагын үйл ажиллагааны танилцуулгыг нэмэлт мэдээллээр хүргэсэн.<br><br>**Аймгийн Удирдах Ажилтны Шуурхай Зөвлөгөөнөөс өгсөн 36-н удаагийн нийт 49-н үүргийг цаг хугацаанд биелэлтийг хүргүүлсэн**. | 100% | |
| 9 | Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөг болгон | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу байгууллагын архивын дүрэм, журам, нягтлан шалгах комиссын журам, албан хэрэг хөтлөлтийн дүрмийг Захирлын А/22, А/23 тоот тушаалын | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх, албан хэрэг хөтлөлтөд уламжлалт Монгол бичиг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх | хавсралтаар баталж, байнга, 70 жил, түр хадгалах хадгаламжийн баримт бичгийг нэг бүрчлэн дугаарласан.<br>2015-2021 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгжийг цахим “AMSG” программд оруулан Төрийн архивт шилжүүлсэн.<br><br>Архивын “AMSG” программд нийт 2808 хуудас баримтыг шивж оруулан 100% цахимжуулан цахим архив үүсгэсэн.<br><br>Архивын ерөнхий газарт Бланк дээр хос бичгээр бичих, “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн мэргэшүүлэх сургалтанд 1 албан хаагч хамрагдсан.<br>Хос бичгээр бичих бланкыг Архивын ерөнхий газраас захиалан авч, бланк дээр хос бичгээр бичих сургалтанд Сан хөмрөгч, хүний нөөцийн албан хаагчийг хамруулж, туршилтаар бланк дээр хос бичгээр бичих албан хэрэг хөтлөлтөд уламжлалт Монгол бичиг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.<br><br>Албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлүүдийг болон байгууллагын гадна хаяг болон албан өрөө тасалгааны хаягжуулалт, албан хаагчдийн энгэрийн тэмдэгийг монгол, кирилл бичгээр хаягжуулсан. | | |
| 10 | Байгууллагад дотоод удирдлагын ERP систем нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, төрийн үйлчилгээний цахим e-mongolia системийг сурталчлах, шаардлагатай үйлчилгээг e-mongolia системд холбох, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх, өргөдөл, гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх | **Төрийн үйлчилгээг цахимжуулах**:<br>• 2022 оны 02 дугаар 28-ны өдөр админ эрх авч байгууллагын 10 албан хаагчдыг бүртгэн ERP системийг нэвтрүүлэн ажиллаж байна.<br>• ERP системийн үүрэг даалгаварын цэсийг ашиглаж 6 албан хаагчидад нийт 24 үүрэг даалгавар өгч ажилласан.<br>Үүнд: Нягтлан бодогч 1, Ном зүйч-3, Сан хөмрөгч хүний нөөцийн ажилтан-5, Программист-5, Номын санч мэдээллийн ажилтан-10<br>• ERP системийн дэд цэсүүдийг бүрэн ашиглаж албан бичиг шилжүүлэх, ирсэн явсан бичгийг тогтмол хүлээн авч, ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн явуулах зэрэг албан байгууллагуудтай холбогдон үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>• 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Төрийн үйлчилгээг | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | цахимжуулах ХУР, ДАН, e-mongolia системийн сургалтанд 7 албан хаагч хамрагдаж, e-mongolia системд 10 албан хаагч бүртгүүлэн ашиглаж байна.<br>• Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагын дарга, нягтлан бодогч нар 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр тоон гарын үсэг авсан.<br>• 2022 оны 07-08 дугаар саруудад 10 албан хаагч тоон гарын үсэг авч эзэмшсэн.<br>• Байгууллагын цахим хуудасыг MNS 6285:2017 стандартын шаардлага хангуулан шинэчилж аймгийн цахим хуудастай холбох ажлын хүрээнд: Байгууллагын цахим хуудсыг шинээр стандартын дагуу хийлгэж цахмаар өргөдөл, гомдол хүлээн авах цэсийг үүсгэж үйлчлүүлэгч иргэдийн өргөдөл гомдолыг цахимаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. | | |
| 11 | Төрийн албан хаагчдыг сургаж, мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчдыг богино хугацааны мэргэшүүлэх болон төрийн албанд анх орсон иргэдийг мэргэшүүлэх анхан шатны, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд шатны давтан сургалтанд хамруулах | ➢ Соёлын яам, СУИС-ийн Соёлын дээд сургуулиас зохион байгуулсан Лавлагаа ном зүйн кридет олгох, Дижитал маркетингийн мэргэжил дээшлүүлэх цахим сургалтад Арга зүйч Д.Нарнай, Ном зүйч А.Чимэгмаа, Номын санч мэдээллийн ажилтан Б.Аасүрэн, Ш.Түмэннаст, Программист Э.Мажирнамхай нарыг хамруулж чадавхжуулсан.<br>5 албан хаагч 6 өдрийн 30-н төрлийн хичээлийн онлайн сургалтад хамрагдаж шалгалт өгч сертификат авсан.<br>➢ 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр ERP, E-Mongolia.mn цахим сургалтад 7 албан хаагч хамрагдсан.<br>➢ “NEW STORY” хөгжлийн хөтөлбөрийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Соёлын яамтай хамтарсан сургалтад 2 албан хаагч хамрагдаж Говьсүмбэр аймгийн Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүнээр сонгогдсон.<br>➢ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ХНУМТ системийн сургалтад 2 албан хаагч, Корнавирист халдвар /ковид-19/-ийн тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам, Манлайллын хэв маяг, хандлага тодорхойлох нь, Алдаа дутагдлыг шийвдэрлэх нь зэрэг сургалтуудад 7 албан хаагч хамрагдсан.<br>➢ Авлигалтай тэмцэх газраас зохион байгуулсан 21 аймгийн шинээр томилогдсон албан тушаалнуудад зориулсан авлигын эсрэг анхан болон дунд шатны сургалтад 7 албан хаагч, Таны эрх таны оролцоо авлигалд үгүй гэж хэлье иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх сургалтад 10 албан хаагч тус тус хамрагдсан.<br>➢ Үндэсний номын сангаас зохион байгуулсан Тогтмол хэвлэлийн улсын нэгдсэн санд орон нутгийн гаргасан тогтмол хэвлэлийг бүртгэж оруулах сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>➢ Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс “Харилцаа хандлага ёс зүйн сэдвээр сургалт захиалан авсан.<br>➢ Хууль эрх зүйн хэлтсээс Авлигын тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчлийн тухай хууль<br>➢ Боржигин Өв Музейгээс Угийн бичгийн сургалт зэрэг байгууллагаас болон бусад  мэдлэг, чадвар, чадамж нэмэгдүүлэх богино хугацааны сургалтанд албан хаагчдыг хамруулан ажилласан.<br>➢ Соёлын салбарын шинэ сэргэлтийн бодлого аймаг, нийслэл, сумдын соёл урлагийн байгууллагуудын удирдлагуудын зөвлөгөөн, салбарын чиглэл бүрийн сургалт хэлэлцүүлэгт хамрагдсан.<br>➢ Онцгой байдлын газраас “Галын аюулгүй байдал”<br>➢ “Хувь хүний хөгжил ба хандлага, сэтгэлгээний өөрчлөлт”<br>➢ “Амар амгалан Говьсүмбэрийн төлөө”<br>➢ Аюулгүй байдал хамгаалалтын академ”-ийн хамгаалалтын ажилтан бэлтгэх “Очир” сургалтын төвд 210 цагийн сургалтад 2 албан хаагч хамрагдаж сертификат авсан.<br>➢ “Mongolian Library update-2022” үндэсний цахим ном зүйн цар хүрээ мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2 албан хаагч хамрагдсан.<br><br>➢ “ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН” төслийн хүрээнд Номын | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12 | | санч, мэргэжилтэнүүдэд орчин үеийн номын сангийн шилдэг туршлагаас хуваалцаж, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах боломжийн талаар Номын санчдыг чадавхижуулах сургалт хэлэлцүүлэгийг Австралийн Элчин Сайдын Яам, Монголын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбоотой хамтран зохион байгуулсан.<br><br>Албан хаагчдыг чадавхижуулах 18-н төрлийн сургалтанд албан хаагчид 100% хамрагдсан. | | |
| 12 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0,5 хувиас доошгүй зардлыг ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зарцуулах | Байгууллагын албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийг үзлэг шинжилгээнд 2022 оны 10 сард албан хаагчид 100% хамрагдсан. | 100% | |
| 13 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлүүлэхэд саадгүй орчин бий болгож барилга, байгууламжийг холбогдох стандартад нийцүүлэх | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэхэд саадгүй орчинг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандартын дагуу тэргэнцэрийн замыг хийлгэхээр Номын сангийн барилгын их засварын зураг төсөвт оруулсан.<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тусгайлан таних тэмдэг бүхий булан байгуулж компьютер, чихэвч, томруулдаг шил, 310 ширхэг сонсдог аудио ном, Сд тоглуулагч, дизи сонсдог номын төхөөрөмжүүдийг байрлуулан Номын сангийн орчин нөхцөл тавигдах шаардлага MNS 5742 2019: стандартад нийцүүлэн үйлчилж байна. | 100% | |
| 14 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11.4.1, 11.4.2 , 11.7 дахь заалтуудыг байгууллагын дотоод журманд оруулан баталсан.<br>➢ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн мэдлэг олгох<br>➢ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Нийт 10 албан хаагчид хамрагдсан**.** | | |
| 15 | Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ирүүлэх | Нийтийн номын сан нь 10 албан хаагчидтай. Ёс зүйн зөвлөл байхгүй учир хариуг 2022.02.07-ны өдрийн 21 тоотоор хүргүүлсэн. Ёс зүйн самбар байршуулсан.<br><br>Албан хаагчдын цалин хөлсний бүтцийн мэдээллийг хавсралтын дагуу гаргаж 2022.04.07-ны өдрийн 59 тоотоор хүргүүлсэн. | 100% | |
| 16 | Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалт аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх, ажлын байрны бэлгийн дарамт, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс хүлээн авч, шийдвэрлэх хэм хэмжээг хөдөлмөрийн дотоод журамдаа тусган хэрэгжилтийг хангаж ажиллах | МУ-ын Хүний эрхийн Үндэсний комиссоос өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д хөдөлмөр эрхлэлтийн бодлого харилцааг жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах буюу ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, талаар нэмж оруулан мөрдөн ажиллаж байна.<br><br>Гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг мэдээллийн самбарт байршуулсан.<br><br>Байгууллагын хэмжээнд хүний эрхэд халдсан зөрчил, дутагдал, гомдол гараагүй болно. | 100% | |
| 17 | Байгууллагын ахмадын сан байгуулж, ажиллаж байсан ахмадууддаа сар шинийн баяр, ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэх, тэдэн рүү чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ зохион байгуулах | Манай байгууллагад харъяалалтай нийт 9 ахмад настанд сар шинийн баяр, Ахмадын баярыг угтаж 737301 төгрөгний хүндэтгэл үзүүлсэн.<br><br>Аймгийн “Ахмадын холбоо”-той хамтран ажиллах гэрээ байгуулж үйл ажиллагааны болон шинэ номын танилцуулга хийж уншигчийн карт нээж, ном хэвлэл олгож үйлчилж байна**.** | 100% | |
| 18 | МУЕ-ийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг | МУЕ-ийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд:<br>Байгууллагын хэмжээнд албан хаагч бүр "Угийн бичиг хөтлөх | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх хүрээнд угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтанд албан хаагчдаа хамруулж, угийн бичиг хөтлүүлсэн байна. | үлгэрчилсэн загвар"-ыг баримтлан өөрийн ураг төрлийн хүрээгээ тогтоон, угийн бичгийн дэвтэрийг хөтлөж, зураглал хийж, шастираа бичсэн.<br>Угийн бичгийн сургагч багшаар номын санч, мэдээллийн ажилтан Б.Аасүрэнг бэлтгэж, угийн бичиг хөтлөх ажил хэвшсэн.<br>"Угийн бичиг хөтлөх аргачлал", "Угийн бичих хөтлөх арга зүй" сургалтад албан хаагчдыг хамруулж, Угийн бичиг хөтлөлтийн талаарх зөвлөлдөх уулзалт 2022 хамт олоноороо оролцсон. | | |
| 19 | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3 хэрэгжилтийг ханган, байгууллагын ажилтан, албан хаагчдын монгол бичгийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, албан өрөө тасалгааны хаяг, нэршил, шошго, зар сурталчилгааг хос бичгээр бичиж байршуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | Монгол бичгийн сургалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд:<br>Л.Лоохууз багшаар монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтуудыг 3 удаа танхимаар авсан.<br>Говьсүмбэр номын сан монгол бичгийн хичээл групп чат нээж Л.Лоохууз багшаар монгол бичгийн дүрмийн хичээлүүдийг өдөр бүр заалган суралцаж байна.<br>14 хоног тутамд Монгол хэлний бодлогын салбар зөвлөл, Соёл, урлагийн газарт монгол бичгийн тайланг хүргүүлэн ажиллаж байна.<br><br>Албан хаагчид монгол бичгээ сурахад Э.Олонцэцэг багшийн гаргасан Үндэсний бичгээ шамдан сурцгаая-1 номыг бие даан ашиглаж байна.<br><br>Монгол бичгийн ахисан шатанд А.Чимэгмаа, Б.Аасүрэн, нар ЧИМЭЭ АПП-ыг ашиглан компьютерээр бичиж сурч байна.<br><br>Монгол бичгийн самбарт "Уран бичлэг", "Зүйр онч үгс", Ойролцоо утгатай үг", Шинэ мэдээ, мэдээлэл", "Монгол бичгийн дүрэм" гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр бичиж байршуулсан.<br><br>Албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн.<br>Албан хаагчдын өрөөний хаягийг болон энгэрийн тэмдэгийг монгол бичгээр бичсэн<br><br>Байгууллагаас зохион байгуулж байгаа ном уншлагын аян болон цаг үеийн мэдээллийг "Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан" пэйж хуудсанд хос бичгээр бичин байршуулж байна.<br><br>Монгол бичгийн самбарыг "Уран бичлэг", "Зүйр онч үгс", Ойролцоо | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | утгатай үг”, Шинэ мэдээ, мэдээлэл”, “Монгол бичгийн дүрэм” гэж ангилан мэдээллийг Монгол бичгээр мэдээлж, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны бүртгэлийг хос бичгээр бичсэн.<br><br>Уншигч, номыг уншиж байгаа хэсэгтээ нугалах, тэмдэглэж муухай болгохоос хамгаалах уншигчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор “НОМЫН ХАВЧУУРГА”-ыг уншигч, хүүхэд багчууд, иргэдэд зориулан 2 төрлөөр номтой холбоотой зүйр цэцэн үг уриалсан сургамжит мэдээлэл зэргийг монгол бичгээр бичиж бэлтгэн 300 ширхэгийг шинээр ирсэн номонд хийж байрлуулсан.<br><br>“Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сан” цахим хуудсуудаар дамжуулан өглөөний мэндчилгээ, онч мэргэн үгсийг хос бичгээр байршуулж иргэдэд хүргэж байна.<br><br>Монгол Улсын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит 19 дэх удаагийн “Бичиг Соёл минь-2022” монгол хэлний бүсийн олипадид Байгууллагын төрөлд хамт олоноороо оролцсон.<br>Ном зүйч А.Чимэгмаа иргэний төрөлд оролцож “Дэд байр” эзэлсэн. | | |
| 20 | Аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/184 дүгээр захирамжийн дагуу байгууллага бүр албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, “Спортын хамтлаг”-ийг байгуулах, төлөвлөгөө, төсөв батлан хэрэгжилтийг ханган ажиллах | Байгууллагын даргын 2021.02.25-ны өдрийн А/25 дугаар тушаалаар албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, спортын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах зорилгоор “Спортын хамтлаг”-г байгуулан ажиллаж байна.<br><br>Монгол Улсын Ерөнхий Сайдын санаачилгаар “Илүүдэл жингүй эртэч монгол” аяны хүрээнд аймгийн биеийн тамир спортын газраас зохион байгуулласан дасгал хөдөлгөөнд хамрагдсан.<br>Байгууллагын нийт албан хаагчдын дархлааг дасгал хөдөлгөөнөөр дэмжиж, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг өдөрт 30 минутаар хийж идэвхитэй оролцож байна. | 100% | |
| 21 | МУ-ын Ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажлыг эрчимжүүлэх | “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 ажлын хүрээнд төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.<br><br>ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн 12 хүүхдийн судалгааг гаргаж ажилласан. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Эцэг эхийн зөвлөлөөс хүүхэддээ тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн заавар, зөвлөмж, боршур тараан өгч ажилласан.<br><br>Хүүхэд багачууддаа анхаарал халамжаа нэмэгдүүлэх талаар дараах зөвлөмж, гарын авлагыг албан хаагчдад тараан өгч, мэдээллийн самбарт байршуулан ажилласан.<br><br>Галын аюулгүй байдал, хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх гал, ус , цахилгаанаас аюулгүй байдлыг хэрхэн хангах хүүхдээ харгалзах хүнгүй гэртээ орхихгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан.<br><br>Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтаж байгууллагын ажилчдын хүүхдүүдийн дунд “номтой нөхөрлөе” уншлага зохион байгуулсан. | | |
| 22 | Үндэсний эх хэл, түүх соёл, боржигин өв соёлоо дээдэлсэн аймаг болох зорилтын хүрээнд Боржигины түүх, өв соёлыг таниулах мэдлэг олгох зорилгоор албан хаагчид болон бусад аймгаас сургалт, туршлага солилцох уулзалтаар ирсэн хүмүүст Боржигин өв музейг үзүүлэх | Боржигин өв музейн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдсан Үндсэн хууль-30, Шагайн харваа, Гэрэл зураг, Даалин, Тусгаар тогтнол зэрэг үзэсгэлэнг 10-н албан хаагчид үзэж сонирхлоо.<br><br>Номын баярын арга хэмжээнд урилгаар ирж оролцсон 4-н зохиолчийг Боржигин өв музей үзүүлж танилцуулсан<br><br>Номын санчдыг чадавхижуулах сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан Австралийн Элчин Сайдын Яам, Монголын Үндэсний Номын Сан, Австралийн Элчин Сайдын яамны хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Х.Өрнөх, Монголын Номын сангийн холбооны гүйцэтгэх захирал М.Даваасүрэн, Анаагаах ухааны төв номын сангийн захирал З.Баярцэнгэл нарыг Боржигин өв музей үзүүлсэн. | 100% | |
| 23 | Байгууллагын албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах | Байгууллагын албан хаагчид урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 10-р сард бүрэн хамрагдсан. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 24 | Ажлын байранд коронавируст халдвар /COVID-19/-аас сэргийлэх мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг мөрдөх | Говьсүмбэр аймгийн засаг даргын 2022.01.19-ны өдрийн А/14 Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлгэх, /халдвар хамгааллын дэглэмийг/ мөрдүүлэх арга хэмжээ авч ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдөн ажилсан.<br><br>Говьсүмбэр аймгийн засаг даргын 2022.02.21-ны өдрийн А/52 Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцлах тухай захирамж гарсантай холбогдуулан 2022.02.22-ны өдрөөс эхлэн номын сангийн уншлагын үйлчилгээг танхимаар явуулж үйл ажиллагаагаа тогтмолжуулсан. | 100% | |
| 25 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | Шилэн дансанд байгууллагын төсөв санхүүгийн ил тод байдлыг сар бүрийн 07-ны дотор 38 мэдээлэл байршуулдаг. | 100% | |
| 26 | Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн сахилга батыг эрхэмлэн өр, авлага үүсгэхгүй ажиллах | 11 дүгээр сарын байдлаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, нийт 122,204,183 сая төгрөгийг цалин хөлс болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зарцуулсан.<br><br>Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж, төсвийн сахилга батыг эрхэмлэн өр, авлага үүсгэхгүй ажилласан. | 100% | |
| 27 | Орон нутгийн өмчийн эзэмшүүлэх гэрээ байгуулах, өмнөх оны өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэх | Төрийн өмчийн тухай хуулийн дагуу өмч эзэмшүүлэх 2022 оны гэрээ байгуулсан. 2021 оны өмч эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэхээр гэрээний биелэлтийг 2022.05.18-ны 86 албан тоотоор хүргүүлсэн. | 100% | |
| 28 | Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах | Төрийн худалдан авах хуулийн дагуу үйл ажиллагааг төлөвлөн Төрийн сангийн хяналтын дор төсвийг зориулалтын дагуу зарцуулан өр төлбөр үүсгэхгүйгээр санхүүгийн гүйлгээг хийж ажиллаж байна.<br>Номын сангийн тухай хуулийн 18.4-т заасны дагуу номын татгалзал, номын борлуулалтын судалгаа болон цахим санал асуулгын дүнг үндэслэн ном хэвлэлийг худалдан авч бүрдүүлсэн. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29 | “Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд хариуцаж авсан өрхийн амьжиргааг дэмжин, амьдралын чанарыг дээшлүүлэхд тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулж, үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнах | Нэг өрх-Нэг ажлын байр төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн сүмбэр сумын 3-р баг Баянбулаг 4-411 тоотод оршин суудаг манай байгууллагад хувиарлагдсан өрхтэйгээ танилцаж өрхийн хөгжлийн төлөвлөгөөний судалгааг авч хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлсэн. | 100% | |
| 30 | Ажлын байр, хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөний тайлан мэдээ, ажлын байрны захиалга, мэдээллийг хууль, журмын дагуу холбогдох газруудад хүргүүлж ажиллах | Ажлын байрны сонгон шалгаруулалтын зарыг ХХҮГ-т бүртгүүлж, байгууллагын цахим сайт, пэйж хуудсанд байршуулдаг. | 100% | |
| 31 | Сан хөмрөгийг цахим номоор нэмэгдүүлэх | Фондын сан хөмрөгийг төсвийн хөрөнгөөр:<br>6 ширхэг 285 төгрөгийн түүхэн роман сонсдог аудио номоор<br>Хандивын хөрөнгөөр 25 ширхэг 295000 мянган төгрөгийн аман зохиол, уран зохиол, яруу найргийн номоор<br>Уран зохиолын 50 ширхэг цахим номыг татаж CD-д буулган шарж<br>Сан хөмрөгийг 107 ширхэг цахим номоор нэмэгдүүлсэн. | 100% | |
| 32 | Нийтийн номын сан болон сум сургуулийн номын санч нарыг чадваржуулах онол дадлага хомолсон арга зүйн сургалт зохион байгуулах | “ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН” төслийн хүрээнд Номын санч, мэргэжилтэнүүдэд орчин үеийн номын сангийн шилдэг туршлагаас хуваалцаж, хэрэглэгч төвтэй үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах боломжийн талаар онол дадалга хосолсон Номын санчдыг чадавхижуулах сургалт хэлэлцүүлэгийг Австралийн Элчин Сайдын Яам, Монголын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбоотой хамтран зохион байгуулсан. | 100% | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 33 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймаг, сумаас хуваарилсан талбайд мод бут тарьж ургуулах. Ойн зурвас, ногоон байгууламж бүхий талбайн мод, бутны арчлалт, хамгаалалтыг хийж, ургалтын хувийг нэмэгдүүэлх | 2022.05.08-ны өдөр Байгууллагын хариуцсан авто замын дагуу баруун талын 2014/11 ойн зурвас газрын талбайн хог ургамлыг түүж цэвэрлэн, шинээр 125 мод тарьж, тогоолон цэнэг усалгаа хийсэн.<br>Ногоон байгууламжийн хамрах талбай авто замын дагуу баруун талын 2014/11 ойн зурвас газарт<br>2020 оноос тарьсан модны нийт тоо 383.<br>Ургасан модны тоо 258.<br>Ургаагүй модны тоо 56<br>Шинээр тарьсан модны тоо 125<br>Ургалт амьдралтын хувь 95%-тай байна. | 100% | |
| 34 | Нийтийн эзэмшлийн хуваарилагдсан талбайн цэвэрлэгээг 7 хоног бүр тогтмол хийж, албан хаагчдад хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх, зөв дадал хэвшлийн талаар сургалт зохион байгуулах, мэдлэг, мэдээллээр хангах, байгууллагын орчинд ангилан ялгах хогийн сав байршуулж, хог хаягдлыг ангилан ялгах хэвшлийг бий болгох | Байгууллагын ойр орчмын 50 метр газрын цэвэрлэгээг 42 удаа, Сүмбэр сумаас хуваарилан өгсөн 1-р сургуулиас Тумбааш дэлгүүр хүртлэх газрын цэвэрлэгээг 14 хоног тутам нийт 24 удаа цэвэрлэж Хоггүй сүмбэр пэйж хуудсанд байршуулсан.<br>2022.05.08-ны Цагдаагийн постноос хойш Баянталын зам дагуу цэвэрлэн шуудайлж орхисон 55 шуудай хогийг портерт ачиж хогийн цэг дээр хаясан. | 100% | |
| 35 | Салбарын хүрээнд шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх чиглэлээр санаачлага гарган ажиллах, үр дүнг тайлагнах | Программын шинэчлэлийн 570,000 төгрөгийг Соёлын яамны соёл гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэгт хүсэлт гарган шийдвэрлүүлж 2022.04.22-ны өдөр “Волвес ХХК”-тай гэрээ байгуулан Lib4 номын сангийн цогц программ хангамжийн шинэчлэлийг хийлгэж Говьсүмбэр аймгийн нийтийн номын сангийн номын электрон каталогийг **GOVISUMBER.LIB4U.NET** линкээр болон QR кодыг уншуулан иргэд уншигчдыг гар утаснаасаа харах боломжийг бий болгосон. | 100% | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРАЛЫГ ТҮР ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРНАЙ